МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 28 өдөр Дугаар А/63 Мөрөн сум

Захирамжийн холбогдох хэсгийг хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.11, 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Газрын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 61 дүгээр зүйлийн 61.1, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 26.2, 28 дугаар зүйлийн 28.1.3, 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, 94 дүгээр зүйлийн 94.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Дэмбэрэлийн Дашнямаас ирүүлсэн өргөдлийг судлан үзэхэд түүний эзэмшлийн Жаргалант сумын Шугуй Жаргал Жигүүр баазын дээд цоорхойд байршилтай, аялал жуулчлал, сувиллын зориулалттай 10,000 м.кв газрын газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгохдоо Захиргааны ерөнхий хуульд заасан мэдэгдэх, сонсох ажиллагааг хууль, журмын дагуу явуулаагүй байх тул Жаргалант сумын Засаг даргын 2020 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн А/72 дугаар захирамжийн хавсралтын 1 дэх заалтыг хүчингүй болгосугай.

2. Дээрх захирамжаар иргэн Д.Дашнямын газар эзэмших эрх сэргээгдсэнтэй холбоотойгоор улсын бүртгэлийн мэдээллийн санд өөрчлөлт оруулж, газар эзэмших гэрээ, гэрчилгээг шинэчлэн олгохыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-д зөвшөөрсүгэй.

3. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг Жаргалант сумын Засаг дарга (Ц.Бямбажав)-д үүрэг болгосугай.

4. Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (М.Алтаншагай)-д үүрэг болгосугай.

ДАРГА Ш.ИДЭРБАЯСГАЛАН